Б.СУМЪЯАБААТАР: Чингисийн алтан ургийн угийн бичиг бол монголчуудын бахархлын бичиг

Ж.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Хүннү гүрний түүх, соёлын шастир болсон "Алтан хүний бичээс"-ийг тайлан уншсан, Чингис болон Монголын бусад их хаадыг нэг газарт оршоосон байх магадлалыг батлах хиамэ 2013 онд сансрын зураг авч-лан хийсэн, (үүнийг нь эрдэмтэн, мэргэжилтнүүдээс бүрдсэн тусгай багийнхан "Гарцаагүй Монголын их хаадын түүхтэй холбоотой" хэмээн дүгнэж, тухайн газрыг төрийн хамгаалалтад авах болсон), хэл шинжлэлийн ухааны доктор Б.Сумъяабаатар гуайтай монголчуудын бахархлын бичгийн талаар ярилцлаа. Магтуухан дүргүй "хачин" зантай тэрбээр энэ удаа ч мөн л жээрэлтэй хийх "юм" ярив.

-Төрийн шагналт, Хөдөлмөрийн баатар Л.Түдэв гуай таны талаар олон талаас нь онцлогтой сайхан "магтаал" бичсэн байна лээ. Тэр дундаас "Б.Сумъяабаатар гурван том цагаан өргөө цогцлоон барьсан хүн" гэсэн нь ямар учиртай юм бэ. Юуны тухай хэлснийг нь тайлбарлаж өгөөч.

-Монгол дахь солонгос судлал, "Монголын нууц товчоо"-ны судлал болон угийн бичиг судлал гурвыг минь хэлсэн шиг байна лээ. Солонгос судлалыг үндэслэгч, Гүүлин улсад илгээсэн монгол хаадын зарлиг бичгүүдийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан шинжээч, "Монголын нууц товчоо", монголчуудын гарвал судлалаар оргил зэвшигчийн зиндаанд хүрсэн гэх зэргээр махос миний тухай бичсэн харагдсан. Тэр агуу, эрхэм хүмүүний онгод нь залрач, сэтгэл нь хөдөлсөн мэт таарсан бололтой. Гэтэл намайг доош татаад гарчиглаж, түүн үнэхээр байгаагүй юм шиг. Түүнийг магтаал нь бий тугай шүүмжлэх нь хүртэл бидэндээ урам хайрлаж, оюуныг хурцалдгийг бодож, ханцуйдаа залбирч суух юм даа.

-Бид өдийг хүртэл "Монголын нууц товчоо"-ноо хятад авиа үсгээр галиглаасан хувилбараар судалж ирсэн. Харин саяхан монгол эхийг нь олсон талаар үнэхээр бахархалтай, оньсогонтой "шууд" мэдээлэл сонслоо.

-Одоо болтол бид монгол хэлээр, хятад авиа үсгээр галиглаасан "Монголын нууц товчоо"-ны тухай л ярьж бичиж, хөрвүүлж, судалж ирсэн шүү дээ. Ер нь энэ бүтээлийг анх монгол үсгээр бичсэн, түүнийг хятадаар галиглаасан гэдэг нь тодорхой л доо. Монгол эх нь олдохгүй байсаар саяхан хэдэн хуудас олдлоо.

-Монгол эх зөвхөн нь тэгээд бидний мэдэж "Монголын нууц товчоо"-ноос ялгаатай зүйл байна уу. Та тэр бүтээлийн хуудсыг үзүүрлэж болох уу?

-Монгол, Өвөрмонгол, Хятадаас биш, бүр Төвдийн номын сангаас "Монголын нууц товчоо"-ны монгол үсгийн эх гарч ирнэ гэдэг бол хэний ч санаанд оромгүй зүйл. Гадаад гарын эрдэмтэд шуурхайлан судалж эхэлтэл. Би хүрсэн "Монголын нууц товчоо"-ны хэсэг эх болон "Алтан товч" зэрэг бусад сурвалжтай зэрэгцүүлэн үзлээ. Өнгөрсөн аравдугаар сарын 15-17-нд Өвөрмонголд "Монголын нууц товчоо" судлалын олон улсын хурал болсон. Надад рашаан ирсэн ч явж чадсангүй. Харин 60 гаруй үгээс агуулал бичээд илгээсэн юм. Таны асуулт байгаа ялгааны талаар. Тэгэхэд бүгдийг нь нэлээдхэн байна. 10 гаруйхан хуудас зүйлд үгээс олон ялгаа гарч байна лээ. "Монголын нууц товчоо" судлаачдын ширүүн хүлээн зөвшөөрдөг зарим зүйлийг эргэж харах, бүр задруулахаар ч зүйл байна лээ. Жишээ хэлэхэд, "үжин" гэдэг үгийг "фүжин" гэдэг хятад үгээс гаралтай гэж эрдэмтэд үздэг. Монгол хүний үгийн нэрээс сахаарсан хятад үг тийм эрт цагт хэлтэрдэг билээ гэж миний мэт нь эргэлздэг байсан боловч баталгаа бармт байсангүй. Гэтэл Төвдийн номын сангаас олдсон монгол үсгийн "Монголын нууц товчоо"-ноос түүхэн баримт гарч ирлээ. "Үжин" гэдэг нь уугал монгол үг. Монгол хэлний "оч", "очин" гэдэг үг болохыг батлан өгүүлж, дэлхийн монгол судлалын эргэлтэд оруулаад. Одоо ч гэсэн ийм нэртэй авирлагч монголч эрдэмтэн бий шүү дээ. Өнөө голын нэрний тухай хэрэг хэд хэдэн сонирхолтой баримт байгаа тухай бичиж санал дэвшүүлсэн юм.

-Тун сонирхолтой юм байна. Мэдээж та үүнийг олон талаас нь "мэрж, мөлжиж" шүү сонирхолтой судалгаа хийнэ. Тэр цагт эргэн ууилъя. Чингис хааны мэндэлсэн өдөр болох гэж байна. Тэгэхээр Чингисийн угийн бичгийн тухай ярилцах уу. Саяхан нэг зөвлөлгөөнөөр угийн бичгийг монголчуудын бахархлын бичиг болгох саналын талаар ярьсан. Та ийм санаачилга гаргасан уу?

-Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Ё.Баатарбилэгийн ярих байна. Хэдэн сарын өмнө "Монгол судлалыг хөгжүүлэх бодлого, чиг хандлага" сэдвээр эрдэмтдийн саналыг сонсох зөвлөгөөн Төрийн ордонд болж, "Чингисийн алтан ургийн угийн бичгийг монголчуудын бахархлын бичиг болгож өгнө үү" гэсэн саналаа тавьсан юм.

-Тэгж үндэслэл бий юу. Угийн бичиг хүртэл тийм чухал юм бэ?

-Монголчууд бид эртний эрдэнэт түмэн болохыг ев их соёл, ерх гэрийн бичмэл түүх бэлхнээ гэрчилнэ. Монголчуудын угийн бичиг бол "Монголын нууц товчоо"-ноос өмнө байсан соёл, дурсгал бөгөөд "Үзүүрийн бичиг" гэсэн нэртэй байсан. Угийн бичиг бол олон мянган хүний жирийн нэг хэлхээс биш. Бодгаль хүмүүсийн нэрээр бичсэн үнэн түүх. Түүх бичлэгийн эртний арга. Сүүл үеийн Дөрвөд дахины албан эх сурвалж, түүхүүдэд "Олон шастир" нэрээр уламжилсан. Монголчуудын угийн бичиг, гэрийн үеийн бичмэл нь толгойтныг бөхийлгөж, тойгтныг сөхрүүлж, сүсэгтнийг залбируулж, сүрэгтнийг дагуулж, номтныг өргүүлж, бичигтнийг дээдлүүлж, билигтнийг цуглуулж ирсэн бидний овог дээдсийн үүх түүх, ев соёл билээ. Угийн бичиг монголчуудын сүнс сүлдэр, бурхан ухаан шингэсэн байдаг юм. Тийм тунхаг бичиг юм. Овог дээдэс минь үе залгамжлаа хольцоогүй, төрийнхөө алтан жолоог цэвэр ариун байлгах хэмжээсэн эртний уламжлалт сонгомол нарийн аргыг бодож олсон нь энэ. Түүнийг чанадлан үе залгамжилж, засаг, төрийн эрхийг барьдаг байсан тул төрийн тэргүүнд харийн хүн шургалах зүүний сүвэгч төдий ч зай гаргахгүй, тийм боломж олгодоггүй байв. Угийн бичиг бол эрдэмтдийн эрлэг, их Монголын сүүн цацал билээ.

Зөвхөн Монголд байгаа гурван гар бичмэл угийн бичгийг судалж буй Б.Сумъяабаатар



Төвдийн номын сангаас олдсон монгол үсгийн "Монголын нууц товчоо"-ны нэг хуудас (V болон IX мөрөнд "Бөртэ Чино" гэсэн байна)

ч учраас 1920-иод оны үеэс харийнхан монголчуудын угийг мартуулах үүднээс ихэнх өмнө угийн бичгээс нь холдуулах санаа өвөрлөн, хадгалж гочилж, эзэст нь зарлигдан хоригдох, хүн хэрэглэх чанд орж, тайж нэгэн, төрийн дарга, бичиг номын мэргэд настнуудыг нь баривчилж хонжсон. Тэр бол монголчуудын угийн бичгийг хар сүүдэр дайрсан жилүүд билээ. Хоорондын зарим нь түр ангийн бэрхийг даалгүй, тайж гарлын нэрийн нэрээ сольж, "ард" гэсэн гарлыг болж ч хоцорсон. Тэр нь нэрээд албан албадлагаар буусан хүмүүс ч бий. Гэвч угийн бичгийг нь монголчуудын эр зүрхнээс салгаж чадаагүй юм. Монгол хүн ухаан зарж, номын сан, архивтаа хадгалуулж, үр, ач нартаа цээжлүүлж, эмэгтэйчүүд нутаг гэж бодсон ч суудалдаа давхиж зөрөөр цөөгүүр цагийг давж ирэв. Одоо оюут хүний тархи шилэн, ухаан үндэрч, бичгийн муу мэдэж сайхан цагтай золголоо, бид. Бид монголчууд. Чингис хааныхан алтан ургийн угийн бичгийг монголчуудын бахархлын бичиг болгон тунхаглах цаг ирсэн болов. Угийн бичиггүй Монгол бол шүншгүй бурхантай адил. Энэ бол сэргүүн түүх биш, бодит ашигтай биргэлэх гэсэн үг.

Чингисийн алтан ургийн угийн бичгийн учир холбогдол, өнөөгийн хэлдгээр ач холбогдол, яагаад бид угийн бичгээ бахархлын бичиг болгон тунхаглах ёстой юм бэ гэвэл:

- Чингисийн алтан ургийн угийн бичиг бол монгол түмний хувь заяаг өөрлөж, бусдаа үүсэхгүйгээр бидний үед ирчихсэн ачлалт ном юм.
- Есөн эрдэнээр номоо бүтээгдийн удам монгол түүргатан бидний оюуны соёлын хосгүй дурсгал. Хүн бүр баримтыг судраа магнайлан өргөж, тэр хоорогоо горилсон тойрч, эрдэм эрхийн бэлгэдэж зааштгэдын удам болсон бидэнээс хүн төрөлхтний дэлхий ирэх соёлын санд оруулсан ул хувирах уламж их хандив нь юм.
- Зорчс бодоход тайж нарын үе залгамжийн энгийн нэгэн бичиг мэт боловч хүн төрт түүхэн сурвалж юм.
- Цус ойртож, бие бөлгөн, ухаан мунхаг, удамшлын өвчинт үр ач нартай болохоос сэргийлэх далд үндэстэй, монголчуудын эрүүл саруулын манаа, эзэс мэндийн баталгаа, нохон уравнүйн эмийн судар юм. Монголчуудыг өвчин эмгэг баригдсан, өтөлж мөхөж буй үндэстэн гэж цээжний бичгээр бичигдэж байсан. Гэтэл угийн бичигт мааньх 17, 18 эргэтэй хүүхэдтэй хүн хүртэл тэмдэглэгдсэн. Эмэгтэй хүүхэд бас байсан байж таарна. Энэ бол мэдэмхийрэгчдийн нүүрийг улайлгах, нүглийг илчлэх баримт даруй мөн.
- Монгол айл бүрийн хэн ч хадгалахгүй шүтээн хэрэгсэл. Одоогийнхоор ерх бүрийн, хүн бүрийн ул хөдлөх хэрэгсэл нь юм.
- Чингисийн алтан ургийн угийн бичиг нь Монгол хэмээх улсын улс төр, төрийн хар хайрцагны бодлогын үндсийг агуулсан өвөг сүнс нь юм. Тодорхой хэлэхэд, угийн бичиг нь монголчуудын тусгаар тогтнолын

Өнөө цаг Чингис хааныг өмчлөх гэж маш цаанаа нь чангаасан үзэгдэж болов. Үүнийг мухарлах, тэдний дургүй болох цорын ганцхан зүйл бий. Тэр нь Чингисийн алтан ургийн угийн бичиг. Тэдэнд "Эх нэгэн, Чингис хаанаас удамтай хань үндэстэнийхээ угийн бичгийг гаргаад ир" гэхэд л хангалттай. Тэдэнд тийм зүйл байхгүй. Харин манайд бол хэдэн мянгаараа байна. Үндэсний номын санд гэхэд л 400 орчим бий. Үндэсний төв архив, хувийн цуглуулагчдын олон чүүтгэлээр, мөн монгол хүн бүрийн гэрт мэдээжид шингээсэн байгаа. Дэлхийн ямар ч оронд байхгүй, зургаан хошуутай гэрийн бүүрийн чанар давуун дээр бийрээр бичсэн нэг хосоо, ЮНЕСКО-гийн соёлын өв, "Гишгийн ном"-д бүртгүүлэх чансааны угийн бичиг манай улсад тэрээн ширхэг байгаа.

Угийн бичигт тухайн хүнтэй холбоотой зүйлээ тэмдэглэх, тухайлбал, түүний хэргэм зэрэг, бичиг үсэг мэдэх, эсэх, угийн бичгийг хөтөлсөн тэрүүн жил хэдэн настай байсан, эрүүл мэнд, зан ааш, ухаан санаа, хүн төлөвийн талаар зүүлт үг хадаж өгсөн байдаг нь тэр бүр таарахгүй байдаггүй, хувь хүний ахуй амьдралын холбоотой, энгийн мөртлөө сонирхолтой баримт ч бий. Жишээлбэл, Сайн ноён хан аймгийн нэгэн угийн бичигт Чүлтэм гэдэг хүний хойно "Өлөө тийж, гучин настай, монгол үсэг ухаж боловсрон сурч буй. Хүн төлөв ухаан маш тодорхой болсон" гэсэн байдаг. Түүгээр ч барахгүй, түүх судлаачдын харааны өртөөгүй, анзааралгүй нэгэн түн нөцтөй түүхэн баримт ч угийн бичигт хадгалагдан үлдсэнийг онцлон нэхэн тэмдэглэхээс зохистой. Юу гэхэл, Манжийг эсэргүүцсэн ахмы хүмүүс бол Чингисийн алтан ургийнхан байжээ. Өөрөөр хэлбэл, Манжийг сөрж эсэргүүцсэн, түүнээс болж хэлмэгдсэн хүмүүсийн түүх угийн бичигт ул ажиглагдам хэлбэрээр товч тодорхой байгаа юм. Түүнийг бичгийн мэргэд маань тун нарийн аргаар, сэмхэн хавчуулан бичиж, хойч үеийнхэндээ үлдээжээ. Угийн бичигт хүний нэрийн өмнө юм уу, хойно нь "Тайжаас байлгасан", "Засгаас байлгасан", "Түшээс байлгасан", "Сайн ноёноос байлгасан" гэх буюу "шилсэн", "цаазалсан" гэж тэмдэглэсэн зүйл олон таардаг. Гуравхан угийн бичигт гэхэд ийм 200 гаруй хүн байна. Бүх угийн бичгийг шүүрдвэл хэдэн мянгад ч хүрч мэдэх нь. Тайж нар бол тухайн цагтаа боловсролтой, гадаад хэлтэй, юм үзэж нүд тайлчихсан сэхээтэн байсан. Манжид үйлчлээгүй, ямар нэгэн хэлбэрээр Манжийг эсэргүүцсэн учраас л тийнхүү шийтгүүлсэн байж таарна. 1911 оны тусгаар тогтнолыг голлох хүмүүс нь ч Чингисийн алтан ургийнхан байсан гэдгийг угийн бичигтэй нь холбон нэхэн санахад илүүдэхгүй. Энэ бүхнээс үзэхэд, Чингисийн алтан ургийн угийн бичгийг монголчуудын бахархлын бичиг болгон тунхаглах бүрэн үндэстэй гэж бодно.

-Энэ бүхнээс үүдэн монголчуудын бахархлын бичиг болгох боломжтой санагдлаа. Санасан сэдсэн оюун бодол тань биелэж болтугай. Солонгос судлаач том эрдэмтэнтэй уулзчихаад бидний түүхтэй асар их холбоотой тэр улсын талаар асуухгүй өнгөрч болохгүй. Ирэх жил тэмдэглэлтэй олон түүхэн үйл явдал тохионо. Энэ талаар мэдээлэх үү?

-Үнэхээр чухал түүхэн үйл явдлууд тохионо шүү. Монгол, Солонгосын анхны "Тангараг гэрээ"-ний 800 жилийн ой болно. Энэ нь "Дайсныг дарсны дараа, ах дүү улс болохоо андгайлъя" хэмээсэн Чингис хааны зарлигаас улбаатай юм шүү дээ. Гүүлин улсын нутагт зугтан орсон Хятаны үлдэгдлийг Чингис хааны их цэрэг дарсан. Ингэхдээ Гүүлин улсын цэрэгтэй хамтран устгасны дараа "Манай хоёр улс түүрэг ах дүү байж, түмэн үе үр сад минь энэхүү өдрийг бүү умартаг" гэж андгайлалцсан байдаг. 1219 оны явдал. Үүний тухай 40 гаруй жилийн тэртээд "Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд" гэдэг бүтээл (1975 он, XIX тал)-д ... хийт түүхэн юм.

Ирэх онд тохиох өөр нэгэн чухал үйл явдал бол Дундад зуунд Монголоос гадаадад 17 000 дэвтэр бүхий 4371 боть ном буюу бүхэл бүтэн номын сан бэлэглэж байснаас 705 жилийн ой юм. Гүүлин улсын ван 1314 оны намар, долоон сарын хөх бар өдөр хүлээж авсан тухайгаа түүхэндээ бичиглэн үлдээжээ. Энэ бол дэлхийн соёлын түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал. Манай Үндэсний номын сангийнхан нэгийг бодож, хоёрыг тунгааж байгаа гэдэгт найдаж сууна даа.

"Манай хоёр улс түүрэг ах дүү байж, түмэн үе үр сад минь энэхүү өдрийг бүү умартаг"

Гүүлин улсын монголын бичгийн үлдэгдэл

баримт